



МОНГОЛ ШИЛТГЭЭН ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 03 дугаар сарын 17

Дугаар 25/ 02

Улаанбаатар хот

Г “Монгол шилтгээн” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит 7 хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1 дахь заалтууд, 2025 оны 3 дугаар сар 17-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээс ирүүлсэн санал, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх” журмыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 14.00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2 дугаар хороо, Самбуугийн гудамж, “Орон зай” төв 7 давхарт 704 тоотод хуралдуулахаар тогтоосугай.

2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар доор дурьдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай.

- Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт
- Ногдол ашиг хувиарлахгүй талаар ТУЗ гаргасан шийдвэрийг танилцуулах
- 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөр тогтоосугай.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тухай зарыг өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр тутмын сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр, 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр дахин мэдээлэх, Монголын хөрөнгийн биржийн сайтад тавих, брокерийн компанид хүргүүлэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.

4. Хурлын зар өгөхтэй холбоотой зардлыг хурал зохион байгуулах комиссын дарга /С. Энхтуяа/-д гаргаж өгөхийг компанийн санхүүд даалгасугай.

5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь Хавсралт 1-д заасан бичиг баримтыг БДК-иудаас авч танилцах эрхтэй болохыг дурьдсугай.

6. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар санал авах “саналын хуудас”-ны агуулгыг хавсралт 2-д зааснаар баталсугай.

7. Компанийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 14.00 цагаар тасалбар болгосугай.

8. Хурал зохион байгуулах хурлыг удирдах дарга, тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- | | |
|-----------------|---------------------------------------|
| • Ч. Амарбаатар | хурал удирдах дарга |
| • С.Энхтуяа | хурал зохион байгуулах комиссын дарга |
| • С. Дагиймаа | тооллогын комиссын дарга |
| • Г.Төрбаяр | гишүүн |

9. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комиссд даалгасугай.

10. Хурал хуралдуулах тухай тогтоолыг гаргаснаас хойш 3 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэлийг Хавсралт 3-д заасан маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг хурал зохион байгуулах комиссын дарга / С.Энхтуяа /-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Ч.АМАРБААТАР/